

**ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХААР ЗОХИОН
БАЙГУУЛЖ БАЙГАА АЖЛЫН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

2015-02-04.

Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Төрийн удирдлагын ил тод нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын “Шинэ Булган” үйл ажиллагааны хөтөлбөрт ил тод нээлттэй тунгалаг, хариуцлагатай, хяналттай хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилтуудыг тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргын хамтарсан удирдамжийн дагуу бүх сумдад ажиллах үеэр сум байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчилж мэдээллэдэг, иргэдийн санал бодлыг сонсдог, тайлангаа иргэдэд тавьдаг арга хэлбэр болон ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт шинжилгээ үнэлгээ хийн, арга зүйн зөвлөмж өгсөн.

Аймаг, сумын Засаг даргын Тамгын газруудад хэвшил болгоод байгаа “Нээлттэй хаалганы өдөр”, “Сум, багийн Засаг дарга нарын 30 минут”, “Агентлагийн дарга нарын иргэдтэй уулзах өдөр”, “Өглөөний цай”, “Иргэний танхим”-ын хэлэлцүүлэг, “Нэг цонхны үйлчилгээ”, “Угтах үйлчилгээ”, “Нүүдлийн Тамгын газар”, “Мэдээллийн богц” зэрэг төрийн үйлчилгээгээр нутгийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд мэдээлэх, үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг ханган ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 411 тогтоолоор шинэчлэн баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам батлах тухай” тогтоол, ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн тухай аймгийн төвийн албан байгууллагуудын дарга, эрхлэгч, сумын Засаг дарга нар, сумдын мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдэд 2-3 удаа дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.

Аймгийн Засаг даргын “Шинэ Булган” үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн Засаг дарга агентлаг, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд “Мэдээллийн ил тод байдлыг хангах” талаар доорх заалтуудыг тусган, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбар болон худалдан авах ажиллагааны албаны мэдээлийн самбарт тендер шалгаруулалтын явц, үр дүнг байнга ил тод, нээлттэй мэдээлж байна.

а.Аймгийн Засаг даргын Тамгын газарт:

- Аймгийн Засаг даргын Тамгын газар нь ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу байгууллагын эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл, болон байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, төр засгийн бодлого шийдвэртэй холбогдсон мэдээ мэдээллийг “мэдээлэх самбар”, орон нутгийн телевиз, LCD, LED дэлгэц буюу цахим мэдээллийн самбараар иргэдэд мэдээллээ хүргэж хэвшээд байна.
- Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах ажлын хүрээнд аймгийн Засаг дарга Тамгын газрын бодлого шийдвэр, үйл ажиллагааны ил тод нээлттэй

- байдлыг хангах ажлыг өргөтгөж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сурталчилгааны бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж байна.
- Аймаг орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, бодлого шийдвэртээ тусгах иргэдийн амьдрал, ахуйд шууд нөлөөлөхүйц шийдвэр гаргахдаа иргэдээрээ хэлэлцүүлж, олон нийтийн санал авч тусгах чиглэлийг нутгийн удирдлагын байгууллагууд баримтлан ажиллаж байна. 2014 онд аймгийн Засаг даргын дэргэдэх ИОНХА-ны Иргэний танхимаар 41 төлөвлөгөөт хэлэлцүүлэг зохион байгуулан, давхардсан тоогоор 1900 орчим иргэн хамрагдаж, шийдвэр гаргах түвшний асуудалд өөрсдийн санал бодлоо тусгасан байна.
 - Нутгийн захиргааны ажлын байрны сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон аймгийн “Шинэ Булган” хэвлэлийн хуудас, “Булганы мэдээ” сонин, Bulgan.gov.mn сайтад тавьж, төрийн албаны шалгалтыг амжилтай зохион байгууллаа.

б. Сүм, байгууллагуудад:

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх ажилд бүтээлчээр хандах талаар сүм, байгууллагууд санаачилга гарган ажиллаж байна. Жишээ нь:

- Бугат, Орхон сумд мобигетэр буюу мессежээр цаг үеийн мэдээ, мэдээлийг иргэддээ цаг алдалгүй шуурхай хүргэж байна. Ихэнх агентлаг, байгууллага сумд цахим үйлчилгээг өргөнөөр ашиглан төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, шуурхай нээлттэй хүргэх ажил хэвшсэн.
- Сумдын Засаг даргын Тамгын газрууд болон агентлагууд эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлээ шинэчлэн тодорхойлж байгууллагын үүдэн хэсгийн хүндэтгэлтэй газарт ил тод байршуулж олон нийтэд мэдээллэж байна.
- Ихэнх сумд байгууллагынхаа ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу мэдээллийн самбарыг шинэчлэн байнга баяжилт хийж иргэдэд шаардлагатай мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлж байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны босго үнийг баримтлан тендер шалгаруулалтын журмуудыг мөрдөн ажиллаж байна.
- 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14 төсөл арга хэмжээ буюу 7,146.6 сая, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 4 төсөл арга хэмжээ буюу 106.6 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 18 төсөл арга хэмжээ буюу 3,599.1 сая, Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 19 төсөл арга хэмжээ буюу 3,945.8 сая, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 2 төсөл арга хэмжээ буюу 130.0 нийт 57 төсөл арга хэмжээ буюу 14,928.1 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөнбөгөөд нээлттэй тендер шалгаруулах журмаар 25, харьцуулалтын аргаар 18, гэрээ шууд байгуулах аргаар 2, зөвлөх үйлчилгээний аргаар 1, төсөл арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн. Тендер шалгаруулалтыг зохион байгуулж байгаа үед Засгийн газрын худалдан авах ажиллагааны вэб сайт www.e-procurement.mn хаяг болон аймгийн Цахим

хуудас bulgan.gov.mn, Монголын өдөр тутмын сонинд тухай бүр зарыг өгч, нийтлүүлж хэвшлээ.

- Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж байгаатай холбогдуулан аймгийн төвийн байгууллагын дарга нягтлан бодогч нарт сангийн яамнаас мэргжилтэн ирж сургалт зохион байгуулж орон нутгийн болон улсын төсвийн байгууллагууд санхүүжилт болон санхүүжилийн гүйцэтгэлийн мэдээ мөн 5,0 сая төгрөгнөөс дээш дүнтэй гүйлгээг шилэн дансанд мэдээллэн ажиллаж байна.
- Хууль тогтоомжийг иргэдэд хүргэх зорилгоор энэ оны 1 дүгээр сард хууль тогтоомжийн цахим санг 16 сум, 1 тосгонд хүргүүлсэн. Ингэснээр иргэд өөрсдийн сонирхсон хууль, эрх зүйн актын лавлагааг өөрийн оршин сууж буй сумын ЗДТГ-аас авах боломжтой болсон бөгөөд сумын алслагдсан багт оршин сууж буй иргэд багийн Засаг даргаараа дамжуулан эрх зүйн актыг бүрэн эхээр нь хэвлүүлэн авч, танилцах боломжтой болсон. Хууль эрх зүйн актыг иргэдэд тайлбарлан таниулах зорилгоор багийн ИНХ-ын үеэр болон иргэд цугласан үед эрх зүйн сургалт сурталчилгааг зохион байгуулан ажиллаж байна.

Хэрэгжилтийн түвшин:

Монгол улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор өгсөн үүрэг болон уг тогтоолоор баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг хангах ажлыг зохион байгуулснаар **үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт 94.5 хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт 93.3 төсөв, санхүүгийн ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт 100 төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт 96.0 нийт дүнгээр 95.5 хувьтай** байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.БАТБОЛД

2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

/ Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан шалгуур үзүүлэлт бүрээр/

2014.02.04

№	Шалгуур үзүүлэлтийг хангах арга хэмжээнүүд		Зохион байгуулсан ажил	Хэрэгжилт /хувиар/
<u>Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал:</u>				
1.1	Дараах зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж	<i>Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;</i>	Төрийн захиргааны байгууллагууд ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу байгууллагын эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл, болон байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, төр засгийн бодлого шийдвэртэй холбогдсон мэдээ мэдээллийг “мэдээлэх самбар”, орон нутгийн телевиз, LCD, LED дэлгэц буюу цахим мэдээллийн самбараар иргэдэд мэдээллээ хүргэж хэвшээд байна.	90
		<i>Албан хаагчийн ёс зүйн дүрэм;</i>	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ёс зүйн дүрмийг шинээр боловсруулан батлуулж, мөрдөж хэвшээд байна.Мөн Ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, дүрмийн хэрэгжилтийг хангахын тулд цуврал сургалтуудыг зохион байгуулж байна.Сум, агентлаг бүр Авилгатай тэмцэх газрын саналыг тусган	100

	байх: Үүнд		байгууллагынхаа албан хаагчийн ёс зүйн дүрмийг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна.	
		<i>Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь;</i>	Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын утасны дугаар, мэйл хаяг, факсын дугаарыг аймгийн веб хуудас болон байгууллагын олон нийтэд нээлттэй ил тод хэсэгт байршуулсан.Аймгийн Засаг даргын 2013 оны А/20 тоот захирамжаар “Аймгийн Засаг даргын Тамгын газарт иргэдийг нэвтрүүлэх журам”, аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч иргэдтэй уулзах хуваарийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
		<i>Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт;</i>	Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалтыг байгууллагын олон нийтэд нээлттэй ил тод хэсэгт, болон аймгийн албан ёсны веб хуудас bulgan.gov.mn, аймгийн Засаг даргын “Шинэ Булган” үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтээр хийгдсэн цуврал товхимолд байршуулсан. Сум байгууллагуудад энэхүү жагсаалт гаргах чиглэл өгсний дагуу ихэнх нь олон нийтэд мэдээллэж хэвшээд байна.	90
		<i>Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар.</i>	Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдад болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд бүртгэл лавламжийн сан, хуулийн www.legalinfo.mn сайтаас өссөн дүнгээр 140 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, шаардлагатай тогтоол шийдвэрийг татан хэвлэж өгсөн. Аймгийн вэб сайт болох www.bulgan.gov.mn сайтад 2014 онд шинээр гарсан захирамж, тушаал, гэрээ, мэдээлэл зэрэг 364 гаруй мэдээллийг оруулаад байна. Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг тухай бүр цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол	100

		шинэчилж байна.	
1.2	Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;	Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон агентлаг, байгууллагууд төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох зорилгоор удирдах албан тушаалтан, албан хаагчид, төсөвт байгууллагуудын төлөөлөл хамтарсан баг бүрдүүлэн, байгууллага, салбарынхаа бодлого чиглэл үйл ажиллагааг мэдээллэхийн зэрэгцээ олон нийтийн санал бодлыг хүлээн авч, газар дээр нь шийдвэрлэх, бодлого, чиглэлдээ тусгах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр”, “Нүүдлийн Тамгын газар”, “Мэдээллийн богц” зэрэг арга хэмжээнүүдийг аймаг, сумын төв болон, хөдөөгийн багуудад зохион байгуулсан.	90
1.3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл, болон хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг “Ард” TV, Сайхан монгол” TV, “TM” TV, “Номин” TV, ASSA.mn, Bulgan.gov.mn, МОНЦАМЭ –ийн веб сайт, “Сайхан аялгуу” FM, “Ардчилал”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Нийгмийн толь”, “Булганы мэдээ” сонин, TV-9, Номин, Тэнгэр, МҮОНРТ-ийн орон нутаг дахь төлөөлөгчөөр дамжуулан мэдээлэл түгээх ажлуудыг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй хүргэж байна.	90
1.4	Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн ямаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	2014 онд Нийтээр дагаж мөрдүүлсэн, хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаагүй.	90
1.5	Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа	Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа төслийг боловсруулахдаа эхний ээлжинд сумдын “Иргэний танхим”-аар хэлэлцүүлэн гарсан	90

	холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх;	саналыг холбогдох мэргэжлийн байгууллагуудаар судлуулан дүгнэлт гаргуулсны үндсэн дээр холбогдох мэргэжлийн байгууллагуудыг байлцуулан, дахин аймгийн “Иргэний танхим”-аар хэлэлцүүлэн гарсан саналыг тусган шийдвэрийн төсөлд тусган, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар оруулсны дараа шийдвэр гаргаж хэвшсэн.	
1.6	Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Сум, агентлагийн өргөдөл хүсэлт, хариуцсан мэргэжилтнүүд иргэдийн өргөдөл хүсэлт хүлээн авах, шийдвэрлэлтийг эргэн мэдээлэхэд цахим системийг ашиглах, нээлттэй утас ажиллуулах, уулзалт, өдөрлөг, зохион байгуулалттай арга хэмжээний үеэр болон бусад байдлаар ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг тусгай дэвтэрт тэмдэглэн, бүртгэлжүүлэх, шийдвэрлэлтийг зохион байгуулан, бодлого шийдвэрт тусгуулах ажлыг хэвшил болгоод байна. Аймгийн Засаг даргын “Шинэ Булган” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Эрх чөлөөтэй- Ардчилсан засаглалтай Булганчууд” зорилт болон Монгол улсын Засгийн газрын “Цахим засаглал” хөтөлбөрийн хүрээнд цахим орчинд иргэдийн санал, өргөдөл хүсэлтийг хүлээн авдаг болсноор өргөдөл гомдлын тоо сүүлийн жилүүдээс 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.	100
1.7	Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвших.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, хүсэлтийг аймгийн нутгийн захиргааны байгууллагууд хүлээн авч шийдвэрлэх ажлыг хууль тогтоомж, захирамж, шийдвэр, дүрэм журмыг чанд баримтлан, хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариу өгч хэвшээд байна. 2014 онд аймгийн хэмжээнд бичгээр 6965, цахим хаягаар 4679, утсаар 4468, биечлэн 3333, 11-11 төвөөр 34 бусад хэлбэрээр 985 нийт 20464 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч 93 хувийг буюу 19757 өргөдлийг шийдвэрлэн	100

		хариу өглөө. Одоо 707 өргөдлийг шийдвэрлэхээр судлан танилцаж байгаа бөгөөд иргэдийг чирэгдүүлсэн, гомдоосон дутагдал гаргалгүй хуулийн хугацаанд хариу өгөн ажиллаж байна.	
ГАРЧ БАЙГАА ҮР ДҮН	<i>Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох ажлын хүрээ өргөжиж, чанар үр нөлөө нь дээшилж байна</i>		
Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн түвшин /хувиар/			94.5
<u>Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал</u>			
2.1	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх;	Булган аймгийн хөгжлийн цогц бодлого, аймгийн Засаг даргын “Шинэ Булган” үйл ажиллагааны хөтөлбөрт аймгийн хэмжээнд хүний нөөцийг хөгжүүлэх зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна. Сум бүр орон нутгийн түвшинд хүний нөөцийн бодлогыг шатчилан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Сум, байгууллагууд хүний нөөцийн сүүлийн 5 жилийн судалгааг нэгтгэн ирэх 5 жилийн төлөвлөлтийг боловсруулж байна. Эрүүл мэндийн газар, Боловсролын газар нь салбарын хэмжээнд мэргэжлийн хүний нөөцөөр хангах бодлогыг батлуулан хэрэгжүүлж байна.	80
2.2	Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгах;	Байгууллага бүр хүний нөөцийн ил тод байдлыг хангах арга замыг үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.	100

		<p>Сум, байгууллагууд албан ёсны цахим хуудсанд хүний нөөцийн ил тод байдал гэсэн дэд хэсгийг үүсгэн хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой мэдээллүүдийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.</p> <p>Мөн байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн дагуу хүний нөөцийн ил тод байдлын самбар ажиллуулж байна.</p>	
2.3	Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлэх;	<p>Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлэхэд дараах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж байна.</p> <p>Байгууллагын дотоодын хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөнд хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд дотоодын хяналт тавьж, үр дүнг тооцох үйл ажиллагааг тусган ажилласан. Дотоодын хяналт шалгалтын багийн бүрэлдэхүүнд албан хаагчдын төлөөлөл оролцуулж, шалгалтын дүнг байгууллагын дотоодын шуурхай зөвлөлгөөний үеэр танилцуулан, цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллалаа.</p>	100
2.4	Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх;	<p>2014 онд давхардсан тоогоор 38 байгууллага 1860 албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авч, дүнг хамт олны хуралд танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. Тухайлбал: Дашинчилэн сум нь төрийн албан хаагчдын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, ажлын байранд өмсөх нэгдсэн дүрэмт хувцас зэргийг шинэчлэн ажилласан, Сэлэнгэ сум нийт төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөлгөөнийг зохион байгуулсан зэрэг онцлог ажлуудыг санаачлан хэрэгжүүлсэн байна.</p>	100
2.5	Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх;	<p>Аймгийн хэмжээнд төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын 93 сул ажлын байрны орон тоог Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас</p>	100

		<p>www.csc.gov.mn , орон нутгийн “Булганы мэдээ” сонин, Булган аймгийн албан ёсны цахим хуудас Bulgan.gov.mn цахим хаягаар нээлттэй зарлан мэргэшлийн шалгалт зохион байгуулах замаар нөхөх арга хэмжээг авсан.</p> <p>Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 6, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалын 7 нийт 15 удирдах албан тушаалын ажлын байрны сул орон тооны сонгон шалгаруулалтын Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас www.csc.gov.mn , орон нутгийн “Булганы мэдээ” сонин, Булган аймгийн албан ёсны цахим хуудас Bulgan.gov.mn цахим хаягаар нээлттэй зарлан холбогдох журам дүрмийн дагуу явуулсан.</p>	
2.6	<p>Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулах.</p>	<p>2014 онд байгууллагын дотоод журамд шинээр өөрчлөлт оруулсан байгууллага байхгүй.</p> <p>Байгууллага бүр хөдөлмөрийн дотоод журамд албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэн зөв шударга болгох чиглэлээр тодорхой заалтуудыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Үүнд: Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу, төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэл үр дүнг хөдөлмөрийн гэрээний гүйцэтгэлийн үр дүнг төлөвлөгөөний гүйцэтгэл, шалгуур үзүүлэлтээр дүгнэх талаар заалт оруулан хэрэгжүүлж байна.</p>	80
ГАРЧ БАЙГАА ҮР ДҮН	<p><i>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд төрийн албанд анх орох иргэнийг шударга нээлттэй байдлаар сонгох, үйл ажиллагаа мэргэшлийн түвшинг шударгаар үнэлж дүгнэхэд ахиц гарч байна.</i></p>		
<p>Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн түвшин /хувиар/</p>			93.3

Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал			
3.1	Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх;	Орон нутгийн төсвийн байгууллагууд нь дунд хугацааны төсвийн төслийг үйл ажиллагаанийн хэтийн төлөвлөгөөний хамт ирүүлснийг нэгтгэн, эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилготой уялдуулан 2015-2017 оны дунд хугацааны төсвийн төслийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга түүний ажлын алба, Гүйцэтгэлийн аудит, Хот тохижилт гэсэн хөтөлбөрүүдийн хүрээнд боловсруулж Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүллээ.	100
3.2	Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байх;	Орон нутгийн төсвийн байгууллагын орлого зарлагын 2014 оны тодотгосон төсвийн хуваарь, 2013 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг баталсан аймгийн ИТХ-ын ээлжит 06 хуралдаанаас гарсан 06/05 тоот тогтоолын хамт байгууллагын мэдээллийн самбар, байгууллагын цахим хуудаст байрлуулж мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлж ажиллаж байна.	100
3.3	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх;	Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн 2013 оны жилийн эцсийн, 2014 оны эхний хагас жилийн тайланг байгууллага бүрээр, зардлын зүйл тус бүрээр дэлгэрэнгүй байдлаар гаргаж мэдээллийн самбарт байрлуулсан. Мөн төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн орлого зарлагын мэдээг нэгтгэн гаргаж аймгийн удирдагуудад хүргүүлж байгаагаас гадна статистикийн портал сайт, байгууллагын цахим хуудас bulgan.gov.mn хаяг мэдээллийн самбарт байрлуулж олон нийтэд хүргэж байна.	100
3.4	Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;	Орон нутгийн 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аймгийн Аудитын газрын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын мэдээллийн самбарт байрлуулж олон нийтэд мэдээлж байна.	100

3.5	Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх;	2014 оны орон нутгийн төсөвт 1 удаа тодотгол хийж төсвийн хуваарийг шинэчлэн мөрдөж ажилласан ба байгууллагын цахим хуудас bulgan.gov.mn болон мэдээллийн самбарт нийтэлсэн	100
3.6	Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх;	Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2008 оны 62 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит байгууллагуудад мөрдөх түрээсийн журам, төлбөрийн хэмжээ”-г сум байгууллагуудад хүргүүлэн мөрдөн ажиллаж байна. Уг журмыг байгууллагынхаа мэдээллийн самбарт, түрээсийн орлогын төлбөр төлсөн байдлыг байгууллагын Веб сайтад, ил тод байдлын самбарт байршуулан албаны ил тод байдлыг ханган олон нийтэд мэдээлэн ажиллажбайна.	100
3.7	Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх.	Түрээсийн төлбөрийн хэмжээг зориулалтынх нь дагуу ялгаатайгаар тогтоон мөрдөн ажиллаж байна. Аймгийн төвийн байгууллагуудаас Булган Мээж ХХК , 1,2-р 11 жил , аймгийн ЗДТГазар , Цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагууд журмын дагуу түрээсийн гэрээ байгуулан, орон нутгийн төсөвт орлогыг төвлөрүүлэн ажиллаж байна. Үүнээс 1-10 жилийн гал тогооны түрээсийн хэмжээг шинээр тогтоох, Спортын сургууль, Цагдаагийн газрыг хүсэлтээр 2014 оноос түрээсийн гэрээг цуцлах албан бичиг ирүүлээд байна.	100
ГАРЧ БАЙГАА ҮР ДҮН		<i>Төсвийн ил тод байдал хангагдаж, төсвийн гүйцэтгэлд тавих олон нийтийн хяналт сайжирч байна.</i>	
Төсөв, санхүүгийн ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн түвшин /хувиар/			100
Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод			

байдал			
4.1	Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ талаар олон нийтэд мэдээлсэн байх;	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтлан ажиллах, аймгийн Засаг даргын захирамжаар баталсан журмыг сум байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлж ажиллах талаар арга хэмжээг аван ажиллаж байна.	100
4.2	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудас /www.e-procurement.mn/-т байршуулан, тогтмол шинэчлэх;	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны босго үнийг баримтлан тендер шалгаруулалтын журмуудыг хэрэглэж байна. 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14 төсөл арга хэмжээ буюу 7,146.6 сая, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 4 төсөл арга хэмжээ буюу 106.6 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 18 төсөл арга хэмжээ буюу 3,599.1 сая, Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 19 төсөл арга хэмжээ буюу 3,945.8 сая, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 2 төсөл арга хэмжээ буюу 130.0 нийт 57 төсөл арга хэмжээ буюу 14,928.1 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөнбөгөөд нээлттэй тендер шалгаруулах журмаар 25, харьцуулалтын аргаар 18, гэрээ шууд байгуулах аргаар 2, зөвлөх үйлчилгээний аргаар 1, төсөл арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн. Тендер шалгаруулалтыг зохион байгуулж байгаа үед Засгийн газрын худалдан авах ажиллагааны вэб сайт www.e-procurement.mn хаяг болон аймгийн Цахим хуудас bulgan.gov.mn , Монголын өдөр тутмын сонинд 1 удаагийн зарыг өгч нийтлүүлж хэвшлээ.	100
4.3	Үнэлгээний хороонд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл /ашиг сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдсэн бол/-ийг оролцуулсан байх;	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.4-т заасны дагуу орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэн, Засаг даргын тамгын газрын ажилтныг оролцуулна	100

		гэж заасны дагуу үнэлгээний хороонд хуулийн 47.3.1 дэх заалтын шаардлагыг хангасан иргэний тогтмол оролцуулдаг.	
4.4	Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлсэн байх;	ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу тендер шалгаруулалтанд оролцохыг хүссэн иргэн аж ахуйн нэгжүүдийн шалгуур үзүүлэлтийг гаргаж мэдээллийн самбарт байрлуулсан. Ж нь: тендерт оролцох ААН байгууллага нь хуулийн этгээдийн бүртгэлтэй байх, тухайн бараа, ажил, үйлчилгээний чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй байх, шүүх болон эрх бүхий байгууллагаар сүүлийн гурван жил тендертэй холбоотой аливаа маргаанд хариуцагч болон нэхэмжлэгчээр оролцоогүй байх ба төлбөр зөрчилгүйг баталсан байх зэрэг г,м	100
4.5	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх	Тендерт оролцсон оролцогчдын талаархи товч мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn хаягаар зарласан зарын үр дүнг мэдээлж хэвшсэн. Байгууллагын цахим хуудсанд шалгарсан оролцогчдын талаархи мэдээллийг байршуулж байна.	100
4.6	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх;	Засгийн газрын худалдан авах ажиллагааны вэб сайт www.e-procurement.mn хаягаар зарын үр дүнг мэдээлдэг. 2014 оны аймгийн худалдан авах ажиллагааны тайланг аймгийн цахим хуудас bulgan.gov.mn . хуудсанд ил тод мэдээлсэн.	100
4.7	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх;	Тендер шалгаруулалттай холбоотой гомдол, зөрчлийг тухай бүр нь хуульд заасан үндэслэлээр шат шатанд нь шийдвэрлэх, мөн дээд шатны байгууллагуудад шийдвэрлүүлэхээр саналаа өгдөг. 2014 онд 5 төсөл арга хэмжээнд гомдол гарч тухай бүр нь шийдвэрлэсэн.	100
4.8	Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчдыг мэргэшүүлсэн байх;	Булган аймгийн Булган суманд 2014 оны 01 сард Төрийн бус байгууллагын төлөөлөл болон төрийн албан хаагчдын 120 гаруй хүнийг хамруулсан Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтыг Худалдан авах ажиллагааны газар, Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв ТББ-тай хамтран амжилттай зохион байгуулан ажиллаа. Үүний үр дүнд Булган	100

		аймагт шинээр 45 хүн А3 сертификат авсан.	
4.9	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх	2014 оны 10-р сард Сангийн яамны дотоод аудитын газраас хийсэн шалгалтын дүнг байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.	80
4.10	Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн байх	2014 онд аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой 5 гомдол гарсан. Гомдолыг тухай бүр нь шийдвэрлэж ажилласан. Байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.	80
ГАРЧ БАЙГАА ҮР ДҮН		<i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй олон нийтээс тавих хяналт сайжирч байна.</i>	
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн түвшин /хувиар/			96.0
ЕРӨНХИЙ ДҮН		Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжүүлтийн нийт түвшин / хувиар/	

БИЕЛЭЛТ ТООЦСОН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Л.БАТБОЛД